**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/114/СТА-ТШЗ***

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор: У.Энхчимэг<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1.Хараат бус аудиторын дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....13
3. Аудитын тайлан ....14
3.1. Ерөнхий зүйл ....14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....15
3.4. Материаллаг байдал ....15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....16
3.7. Шилэн дансны мэдээлэл ....16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....17
3.9. Аудитын илрүүлэлт ....17
Залруулсан алдаа ....17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....20

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 324

танай__________-ны №__________-т

БҮСИЙН ОНОШИЛГОО
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.ДОЛЖИН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **783,065,224.54** | **966,844,931.16** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 19,833,000.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 19,833,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 783,065,224.54 | 947,011,931.16 |
| **351** | **Түүхий эд материал** | 722,206,236.49 | 901,526,605.16 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 603,465,090.70 | 694,721,576.70 |
| 35130 | Эм боох материал | 118,741,145.79 | 206,805,028.46 |
| **354** | **Хангамжийн материал** | 44,798,988.05 | 27,210,326.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,620,888.00 | 6,552,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 13,589.00 | 1,455,696.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,564,730.05 | 1,567,540.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 25,672,160.00 | 17,634,390.00 |
| 35600 | Мал амьтад | 16,060,000.00 | 18,275,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,227,011,652.00** | **12,338,797,449.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12,227,011,652.00 | 12,338,797,449.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 11,087,284,318.72 | 11,197,707,116.74 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,483,152,338.00 | 9,076,282,074.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -417,080,959.28 | -600,494,878.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 918,438,340.00 | 918,438,340.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -889,532,041.74 | -901,711,595.84 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 9,071,827,201.04 | 8,727,187,927.98 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,204,401,730.82 | -6,144,835,670.03 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 357,314,967.55 | 366,593,605.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -251,078,712.01 | -263,314,375.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 43,543,756.00 | 46,505,756.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -24,898,840.02 | -26,944,067.34 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,139,727,333.28 | 1,141,090,333.24 |
| 39301 | Програм хангамж | 2,963,750.00 | 4,463,750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,461,416.72 | -2,598,416.76 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,139,225,000.00 | 1,139,225,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **13,010,076,876.54** | **13,305,642,381.14** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **10,406,000.00** | **53,895,220.90** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 10,406,000.00 | 53,895,220.90 |
| **413** | **Өглөг** | 10,406,000.00 | 53,895,220.90 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 37,730,170.90 |
| **4136** | **Бусад өглөг** | 7,606,000.00 | 16,165,050.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,606,000.00 | 16,165,050.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **12,999,670,876.54** | **13,251,747,160.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 12,999,670,876.54 | 13,251,747,160.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 11,168,758,824.11 | 11,168,758,824.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 11,168,758,824.11 | 11,168,758,824.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -1,112,045,106.57 | -859,968,822.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,112,045,106.57 | -1,112,045,106.57 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 252,076,283.70 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,942,957,159.00 | 2,942,957,159.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **13,010,076,876.54** | **13,305,642,381.14** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **12,702,726,910.51** | **13,014,071,430.88** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,833,765,170.18** | **1,606,518,531.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,833,765,170.18 | 1,606,518,531.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,833,765,170.18 | 1,606,518,531.58 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 208,506,242.00 | 263,712,077.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,625,258,928.18 | 1,342,806,454.58 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,868,961,740.33** | **11,407,552,899.30** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 255,791,522.33 | 333,291,990.25 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,505,000.00 | 19,563,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 186,286,522.33 | 298,960,447.25 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 5,473,811,400.00 | 6,332,835,300.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,473,811,400.00 | 6,332,835,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,139,358,818.00 | 4,741,425,609.05 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,139,358,818.00 | 4,741,425,609.05 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **10,997,708,256.47** | **12,761,995,147.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,997,708,256.47** | **12,761,995,147.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,979,110,383.79 | 12,717,536,964.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,435,956,826.97 | 7,611,121,516.00 |
| 210101 | Үндсэн цалин | 3,952,000,126.97 | 4,433,271,655.82 |
| 210102 | Нэмэгдэл | 1,737,212,400.00 | 2,561,595,860.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 346,500,000.00 | 309,225,000.00 |
| 210104 | Урамшуулал | 400,244,300.00 | 307,029,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 805,060,646.15 | 954,947,612.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 549,791,001.33 | 660,610,189.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 63,557,544.82 | 70,113,989.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 51,123,200.00 | 56,160,259.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,780,800.00 | 15,278,469.04 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 127,808,100.00 | 152,784,704.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 416,170,199.40 | 471,703,572.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 110,225,501.00 | 118,956,422.90 |
| 210302 | Түлш, халаалт | 130,972,034.00 | 143,537,035.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 174,972,664.40 | 209,210,114.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 142,832,001.52 | 211,564,220.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,869,806.00 | 23,151,592.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 61,805,475.00 | 58,325,893.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,246,390.52 | 7,842,699.62 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,375,400.00 | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 34,722,540.00 | 34,507,575.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,692,390.00 | 11,042,391.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,120,000.00 | 76,634,070.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,006,873,306.96 | 2,296,449,393.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,788,724,090.51 | 2,025,898,582.50 |
| 210502 | Хоол, хүнс | 218,149,216.45 | 267,127,971.05 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 97,577,010.00 | 165,103,208.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,785,300.00 | 2,785,263.00 |
| 210604 | Урсгал засвар | 94,791,710.00 | 158,855,595.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,614,250.00 | 8,987,180.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,614,250.00 | 8,987,180.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 53,775,553.00 | 81,564,524.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,781,393.00 | 45,637,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 909,100.00 | 4,999,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 271,000.00 | 307,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 297,000.00 | 297,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,404,000.00 | 7,046,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,999,992.00 | 2,976,864.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 666,500.00 | 642,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 19,546,568.00 | 18,858,760.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,003,250,589.79 | 916,095,738.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,796,059.00 | 10,900,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,730,460.00 | 3,482,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 945,724,070.79 | 901,713,438.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18,597,872.68 | 44,458,182.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,205,367.00 | 22,617,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,205,367.00 | 22,617,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 392,505.68 | 21,840,782.47 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 392,505.68 | 21,840,782.47 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,705,018,654.04** | **252,076,283.70** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,705,018,654.04** | **252,076,283.70** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **10,077,467,982.33** | **11,671,264,976.30** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **208,506,242.00** | **263,712,077.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 208,506,242.00 | 263,712,077.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 208,506,242.00 | 263,712,077.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 208,506,242.00 | 263,712,077.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,868,961,740.33** | **11,407,552,899.30** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 255,791,522.33 | 333,291,990.25 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,505,000.00 | 19,563,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 186,286,522.33 | 298,960,447.25 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 5,473,811,400.00 | 6,332,835,300.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,473,811,400.00 | 6,332,835,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,139,358,818.00 | 4,741,425,609.05 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,139,358,818.00 | 4,741,425,609.05 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **10,077,467,982.33** | **11,671,264,976.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,077,467,982.33** | **11,671,264,976.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **10,054,928,409.65** | **11,606,973,793.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,443,951,665.79 | 7,613,482,866.60 |
| 210101 | Үндсэн цалин | 3,960,024,965.79 | 4,093,718,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,737,182,400.00 | 2,559,206,366.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 346,500,000.00 | 346,500,000.00 |
| 210104 | Урамшуулал | 400,244,300.00 | 614,057,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 804,018,531.33 | 955,386,261.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 548,402,331.33 | 659,828,561.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 63,904,100.00 | 73,889,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 51,123,200.00 | 59,111,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,780,800.00 | 14,777,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 127,808,100.00 | 147,778,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 416,170,199.40 | 471,703,572.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 110,225,501.00 | 118,956,422.90 |
| 210302 | Түлш, халаалт | 130,972,034.00 | 143,537,035.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 174,972,664.40 | 209,210,114.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 156,894,365.52 | 160,489,023.62 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 15,032,078.00 | 23,012,870.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 67,885,051.00 | 59,768,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,247,410.52 | 7,842,699.62 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,375,400.00 | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 34,722,540.00 | 37,461,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,631,886.00 | 32,343,494.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,940,460,704.61 | 2,121,443,188.69 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,677,137,228.11 | 1,824,200,717.69 |
| 210502 | Хоол, хүнс | 222,668,866.50 | 267,130,781.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 40,654,610.00 | 30,111,690.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 157,139,521.00 | 174,397,107.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 46,053,366.00 | 33,051,950.00 |
| 210602 | Тавилга | 9,996,800.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,785,300.00 | 2,785,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 98,304,055.00 | 138,559,857.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,614,250.00 | 8,987,180.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,614,250.00 | 8,987,180.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52,430,103.00 | 97,602,294.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,651,393.00 | 51,270,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 909,100.00 | 4,999,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 271,000.00 | 307,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 297,000.00 | 297,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,404,000.00 | 10,959,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,550,100.00 | 2,976,864.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 666,500.00 | 642,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 14,781,010.00 | 25,350,730.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 66,249,069.00 | 3,482,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,214,559.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,034,510.00 | 3,482,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,539,572.68** | **64,291,182.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,147,067.00 | 22,617,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,147,067.00 | 22,617,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 392,505.68 | 41,673,782.47 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 392,505.68 | 41,673,782.47 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 11,168,758,824.11 | 2,942,957,159.00 | -2,817,063,760.61 | 00.00 | 11,294,652,222.50 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,168,758,824.11** | **2,942,957,159.00** | **-2,817,063,760.61** | **00.00** | 11,294,652,222.50 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,705,018,654.04 | 00.00 | 1,705,018,654.04 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,168,758,824.11** | **2,942,957,159.00** | **-1,112,045,106.57** | **00.00** | 12,999,670,876.54 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,168,758,824.11** | **2,942,957,159.00** | **-1,112,045,106.57** | **00.00** | 12,999,670,876.54 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **11,168,758,824.11** | **2,942,957,159.00** | **-1,112,045,106.57** | **00.00** | 12,999,670,876.54 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 252,076,283.70 | 00.00 | 252,076,283.70 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **11,168,758,824.11** | **2,942,957,159.00** | **-859,968,822.87** | **00.00** | 13,251,747,160.24 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 11,655,936,800.00 | 11,337,972,986.05 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 11,655,936,800.00 | 11,337,972,986.05 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,645,936,800.00 | 11,307,857,191.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 7,546,943,200.00 | 7,546,943,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 4,093,718,700.00 | 4,093,718,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,492,666,700.00 | 2,492,666,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 346,500,000.00 | 346,500,000.00 |
| 210104 | Урамшуулал | 614,057,800.00 | 614,057,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 962,507,300.00 | 955,386,261.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 666,949,600.00 | 659,828,561.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 73,889,400.00 | 73,889,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 59,111,500.00 | 59,111,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,777,900.00 | 14,777,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 147,778,900.00 | 147,778,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 472,702,100.00 | 471,703,572.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 113,667,000.00 | 118,956,422.90 |
| 210302 | Түлш, халаалт | 142,689,300.00 | 143,537,035.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 216,345,800.00 | 209,210,114.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 127,724,400.00 | 120,132,445.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,038,000.00 | 6,970,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 59,768,000.00 | 59,768,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,842,700.00 | 7,842,699.62 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 36,166,800.00 | 36,166,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,908,900.00 | 9,384,646.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,391,027,600.00 | 2,077,539,835.69 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,094,980,800.00 | 1,788,044,914.69 |
| 210502 | Хоол, хүнс | 259,400,000.00 | 259,383,231.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 36,646,800.00 | 30,111,690.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 63,708,200.00 | 56,294,946.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,209,900.00 | 10,146,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,785,300.00 | 2,785,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 50,713,000.00 | 43,363,546.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,568,600.00 | 8,225,780.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 9,568,600.00 | 8,225,780.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 71,755,400.00 | 71,631,150.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,800,000.00 | 34,800,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 900,000.00 | 800,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,999,500.00 | 4,999,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 228,900.00 | 228,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 265,500.00 | 265,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,959,000.00 | 10,959,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,728,700.00 | 1,728,700.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 666,000.00 | 642,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 17,207,800.00 | 17,207,550.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10000000.00 | 9999000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,000,000.00 | 9,999,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 9,999,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 11,655,936,800.00 | 11,337,972,986.05 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 6,332,835,300.00 | 6,332,835,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 6,332,835,300.00 | 6,332,835,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,067,717,400.00 | 4,741,425,609.05 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,067,717,400.00 | 4,741,425,609.05 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 255,384,100.00 | 263,712,077.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 255,384,100.00 | 263,712,077.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 500.00 | 500.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 308.00 | 308.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 190.00 | 190.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **311,735,002.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **311,735,002.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 299,116,602.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 66,539,666.60 |
| 210102 | Нэмэгдэл | 66,539,666.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,356,578.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,042,570.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,295,160.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,958,848.00 |
| **2105** | **Норматив зардал** | 43,903,353.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,155,803.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,747,550.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 118,102,161.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,905,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 95,196,311.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 761,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 761,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,971,144.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,470,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 31,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,248,164.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,143,180.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3482300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,482,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12618400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,618,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,618,400.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 333291990.25 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 333,291,990.25 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,767,743.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,563,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 298,960,447.25 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Должин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 сарын 01-нээс 2021 оны 02 сарын 19-ний хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“2020 он-Сувилагч , эх баригчийн жил” уриатай ( ДЭМБ)

1. Сувилахуйн хүний нөөцийг хөгжүүлэх ажилд дэвшил гаргах
2. Сувилахуйн тусламж үйлчилгээнд эрсдэлийг үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх
3. Сувилахуйн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай багаж хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх

Оношилгоо эмчилгээний чиглэлээр:

1. Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээг оношилгоо эмчилгээнд нэвтрүүлэх (өвдөг түнхний үе солих, хүзүү нурууны хугарлыг бэхлэх, бөөр шээсний замын дурангийн мэс засал)
2. Дутуу нярайд үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлэх
3. Сэргийлж болох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэх
4. Зонхилон тохиолдох хавдрын илрүүлэг скрининг шинжилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх

Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах

1. Ажилтны эрүүл мэнд
2. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал
3. Хүүхдүүд бидний ирээдүй- нөлөөллийн сургалт, зөвлөгөө

Сэтгэлд шингэсэн үйлчилгээ

1. Үйлчлүүлэгчийн хүсэл зорилго бол өөрчлөлтийг хийх гол үнэ цэнэ

Байгууллагын хэмжээнд сэтгэлд шингэсэн үйлчилгээг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ийн дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 12,761,995.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 255,239.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 295,565.5 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 19,833.00 | 19,833.00 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 783,065.22 | 947,011.93 | 163,946.71 |
| Үндсэн хөрөнгө | 12,227,011.65 | 12,338,797.45 | 111,785.80 |
| Нийт хөрөнгө | 13,010,076.88 | 13,305,642.38 | 295,565.50 |
| Өр төлбөр | 10,406.00 | 53,895.22 | 43,489.22 |
| "Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/" | 12,999,670.88 | 13,251,747.16 | 252,076.28 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 13,010,076.88 | 13,305,642.38 | 295,565.50 |

Авлага оны эхнээс 19,833 төгрөгөөр өссөн байна. Тус авлага нь Сангийн яамны Төрийн сангийн газраас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 947,011.93 мянган төгрөг болж 163,946.71 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн яам, ААНБ, иргэдээс бараа материалын хандив тусламж олгосонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,338,797.45 мянган төгрөг болж 111,785.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж олгосонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 53,895.22 мянган төгрөг болж 43,489.22 мянган төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгчдийн өр төлбөрийг тайлант хугацаанд барагдуулаагүйгээс үүссэн байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,251,747.16 мянган төгрөг болж 252,076.28 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээр өссөн байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 311,344.5 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,764,286.8 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Цар тахалтай холбоотойгоор эм, эмнэлгийн хэрэгслийн зардал, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн хэрэгцээ шаардлага ихэссэн буюу үнэ нэмэгдсэн зэрэг шалтгаанаас эм, эмнэлгийн хэрэгслийн зардал нэмэгдсэн.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13,918,420.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 13,918,420.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,262,483.2 мянган төгрөгөөр бууруулж 11,655,936.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,655,936.8 мянган төгрөгийн төсөв батлалснаас улсын төсвөөс 6,332,835.3 мянган төгрөг, ЭМД-аас 5,067,717.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 255,384.1 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,332,835.3 мянган төгрөгийн, ЭМД-аас 4,741,425.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 263,712.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 11,337,972.9 мянган төгрөгийг зарцуулж 20,116.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,337,972.9 мянган төгрөг буюу 97,3 хувьтай байна. ЭМД-аас авах санхүүжилт 326,291.7 мянган төгрөгөөр тасарсан нь гүйцэтгэл дутуу

улмаас авч чадаагүй байна. Энэ нь цар тахлын хөл хориотой холбоотойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээ авах үйлчлүүлэгчийн тоо эрс багассан нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 22,563.8 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Үүнээс 17,863.8 мянган төгрөгийг ковид цар тахлын бэлэн байдлын үед ажилласан эмнэлгийн ажиллагсдын илүү цагийн хөлсөнд, мөн аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон шуурхай удирдлагын багийнханд 1,700.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулалд олгосон байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ХАА-ны төлөвлөгөө бүтэн жилээр мэдээлээгүй, ХАА-н тайлан бүтэн жилээр мэдээлээгүй, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 1-9 сард мэдээлээгүй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 140 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хоцроож мэдээлсэн 9 мэдээлэл байна. Нийт 1988812,2 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт, 1 зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийг биелүүлсэн байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 103910,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 103910,9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгсөн.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 103,910.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 103,910.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө , тайлан зэргийг бүтэн жилээр мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 1-9 сард

мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ",

6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалт, үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх.

2.Тайлант хугацаанд түр эзгүй ажилтны оронд хавсран болон орлон ажилласан 122 ажилтанд 65,455.3 сая төгрөгийн нэмэгдэл цалинг олгохдоо 40 хувиас илүүгээр тооцон олгосон нь Засгийн газрын 1995 оны 6 сарын 14-ний 96 дугаар тогтоолын "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчийн хувьд түүний албан тушаалын сарын цалин, нэмэгдэл хөлсний дүнгийн тус тус 40 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосугай" , Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын "Түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын 40 хүртэлх хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх.

3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн үнэлгээг Сангийн сайдын баталсан үнэлгээний маягтын дагуу хийгээгүй, аж ахуй материал худалдан авах тендерийг 6 удаа зарласан, тендер амжилтгүй болсон шалтгааныг судалж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, гэрээ шууд байгуулсан тохиолдолд хуульд заасны дагуу Сангийн яаманд тайлбар хүргүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.1-т заасан "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", *34.3*-т заасан Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэх.

4. 2020 оны жилийн эцсийн тооллогыг хийсэн боловч тооллогоор актлах хөрөнгө болон бараа материалын жагсаалтыг гаргаж Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна. Тайлант хугацаанд ашиглалтад байсан, ашиглалтын хугацаа дууссан бараа материалын дүнг гаргаж зардалд бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн

1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах; 5/ эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих гэж заасныг, УСНББОУС-12 Бараа материал, үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1.Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 1 тендерийг 6 удаа зарласан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй.

2.Түр эзгүй ажилтны оронд хавсран, хослон, орлон ажилласан ажилтанд олгож байгаа нэмэгдэл хөлсийг 40%-иас хэтрүүлж олгохгүй байх асуудал нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| **2020** | | | ДОА-2021/114/СТА-ТШЗ |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Бүсийн оношилгоо эмчилгээний төв | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн зарим зүйл, заалтыг мөрдөөгүй. | 35,455.6 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| 2 | Цалингийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоол зөрчин илүү олгосон. | 68,455.3 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| 3 | Жилийн эцсийн тооллогын үр дүнг тайланд тусгаагүй. Холбогдох хуулийн хэрэгжилт хангалтгүй. | 0.00 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| 4 | Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй. | 0,00 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Д.Должин Ө.Сийлэгмаа |
| **ДҮН** | | **103,910.9** | | | |